



MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 03 сарын 11-ны өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот


**Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсад
охин компани байгуулахыг зөвшөөрөх тухай**

Говь ХК-ийн гадаад зах зээлийг тэлэх, онлайн борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор Их Британи улсад борлуулалтын сувгаа нээх нь зүйтэй гэж үзэн, Компанийн дүрмийн 1.6-д үндэслэн Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ НЬ:**

Нэг. Их Британи улсад Говь ХК-ийн 100% эзэмшил бүхий охин компанийг “Gobi Cashmere UK LTD” нэртэй, хязгаарлагдмал хувьцаат компанийн хэлбэртэй бөгөөд нийт 1,000 ширхэг хувьцаатай, хувьцааны нэгж үнэ нь 1 фунт стерлинг байхаар байгуулсугай.

Хоёр. Тус охин компанийн захирлаар Баатарсайхан овогтой Амарсайханыг томилохыг зөвшөөрсүгэй.

Гурав. Охин компани байгуулахтай холбоотой үйл ажиллагааг Монгол улсын болон Их Британи улсын хууль, дүрэм, журамд нийцүүлэн зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Ц.Баатарсайхан/-д даалгасугай.

ТУЗ-ийн ДАРГА:		Д.ГЭРЭЛМАА
ТУЗ-ийн ГИШҮҮД:		Ц.БААТАРСАЙХАН
		М.БАЯР
		Б.НАНДИН-ЭРДЭНЭ
		Ж.ОЮУНЧИМЭГ
		А.ЖАРГАЛМАА
		ТАКЭШИ КАМБЭ
		ХИДЭО САВАДА
		Д.ХУЛАН